МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 25

"ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН"-ИЙН ХЭРЭГЛЭГЧ НАРТ ЗОРИУЛСАН 3 ДУГААР ЭЭЛЖИЙН СУРГАЛТ ЭХЭЛЛЭЭ



Прокурорын байгууллагаас "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-г улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд систем хэрэглэгч нарт зориулсан сургалтыг үе шаттай зохион байгуулж байгаа бөгөөд 3 дугаар ээлжийн сургалтыг эхлүүлээд байна.

Өнгөрсөн хугацаанд 21 аймгийн нийт 3700 гаруй эрх бүхий албан хаагчдыг оролцуулан бүсчилсэн сургалт зохион байгуулсан. Мэдээллийг **ЭНД** дарж үзнэ үү.

Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглэгч нарт зориулсан энэ ээлжийн сургалтад Нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын нийт 4,260 орчим алба хаагчийг оролцуулахаар төлөвлөж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар, Оюуны өмчийн газрын эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулаад байна.

Сургалтаар Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд зөрчлийн гомдол мэдээллийг хэрхэн бүртгэх, ашиглах талаар практик сургалт зохион байгуулж, Зөрчлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар мэдээлэл өглөө.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1110